



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ДАДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 05 сарын 05 өдөр

Дугаар 1143

Дадал сум

**Засаг даргын нөөц сангаас зардал
гаргах тухай**


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралт “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.5, 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Чингис хотноо жил бүр зохион байгуулагддаг “Яргуй-2025” хүүхдийн урлагийн их наадам, Улаанбаатар хотод зохион байгуулагдаж буй “Төрөлх монгол хэл” уран бичгийн Улсын Х уралдаан болон “Монгол бичгийн тэргүүний уншигч” шалгаруулах Улсын XIX уралдаанд Ерөнхий боловсролын сургуулиас төлөөлөн тус тус оролцож байгаа хүүхдүүдийн очиж ирэх унааны шатахууны дэмжлэг үзүүлэх зардал гаргасугай.

2. Чингис хот руу дизель түлш 150 литрийн 510,000 (Таван зуун арван мянга) төгрөг, А-92 бензин 100 литрийн 264,000 (Хоёр зуун жаран дөрөв мянга) төгрөг, Улаанбаатар хот руу 45 литрийн 118,800 (Зуун арван найман мянга найман зуу) төгрөг, нийт зардлын 892,800 (Найман зуун ерэн хоёр мянга найман зуу) төгрөгийг Засаг даргын нөөц сангаас гарган зарцуулахыг нягтлан бодогч (Д.Энхзул)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Санхүүгийн албаны дарга (Д.Агаармандал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.МӨНХХУЯГ

010000220